



DEFENSE RESEARCH
INSTITUTE OF MONGOLIA

Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.01.005>

Some Issues Related to the Use of Social Media as a Tool of Cognitive Warfare

Boldbaatar Amartur

¹Researcher, Center for defense research, Defense Research Institute of Mongolia
E-mail address: amartur.boldbaatar@gmail.com, ORCID: 0009-0009-2801-6753

Received: 03 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 23 March 2026

Published online: 30 March 2026



ABSTRACT

In recent years, social media has evolved beyond a mere tool for information exchange and has transformed into a strategic space that systematically influences individual, societal, and political perceptions, values, and decision-making processes. This article examines the role of social media within the theoretical framework of cognitive warfare, aiming to identify the key mechanisms and emerging challenges that contribute to its weaponization. The study employs theoretical analysis, logical reasoning, and comparative methodology to demonstrate how social media generates threats within the cognitive domain through narrative construction, algorithm-driven influence, and behavioral manipulation. The findings underscore the necessity of recognizing the cognitive domain as an integral component of national security and highlight the urgent need to strengthen cognitive resilience at the policy level.

Keywords: cognitive warfare, social platform, algorithm, national security, resilience.

Олон нийтийн сүлжээг танин мэдэхүйн дайны хэрэгсэл болгож буй зарим асуудал

Болдбаатар Амартөр

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Батлан хамгаалах судлалын
төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ахлах дэслэгч,
amartur.boldbaatar@gmail.com, ORCID: 0009-0009-2801-6753

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд олон нийтийн сүлжээ нь зөвхөн мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа больж, хувь хүний өдөр тутмын амьдрал, улс төрийн оролцоо, нийгмийн харилцаанд гүн нэвтэрч, бодит байдлыг хүлээн авах, үнэлэх арга хэлбэрийг өөрчилж улмаар нийгмийн ухамсар, итгэл үнэмшил, үнэт зүйлд нөлөөлөх болсон тухай, тэр нь танин мэдэхүйгээр дамжин хүний ухамсар нөлөөлж, үндэсний аюулгүй байдалд шинэ сорилтыг бий болгож байгааг болон НАТО болон барууны судлаачид хүний сэтгэхүйг “шинэ тулааны талбар” гэж үзэх болсны учир холбогдлыг тайлбарласан өгүүлэл болно. Мөн танин мэдэхүйн дайн (cognitive warfare)-ы онолын хүрээнд олон нийтийн сүлжээний гүйцэтгэх үүргийг шинжилж, түүнийг зэвсэгжүүлэхэд нөлөөлж буй гол механизм болон тулгамдсан сорилтуудыг тодорхойлохыг зорилго.

Түлхүүр үгс: танин мэдэхүйн дайн, олон нийтийн сүлжээ, алгоритм, үндэсний аюулгүй байдал, сөрөн тэсвэрлэх чадавч

I. Оршил

XXI зуунд мэдээлэл нь үндэсний хүч чадлын чухал бүрэлдэхүүн хэсэг болж, мэдээллийн орчин нь уламжлалт хуурай газар, агаар, тэнгис эн зэрэгцэх стратегийн талбар болон өргөжсөн. Ялангуяа олон нийтийн сүлжээ нь хувь хүний өдөр тутмын амьдрал, улс төрийн оролцоо, нийгмийн харилцаанд гүн нэвтэрч, бодит байдлыг хүлээн авах, үнэлэх арга хэлбэрийг өөрчилж байна.

Энэхүү өөрчлөлт нь аюулгүй байдлын шинэ сорилтыг бий болгож, улс орнуудын хоорондын өрсөлдөөн зөвхөн цэргийн хүчээр бус, харин нийгмийн ухамсар, итгэл үнэмшил, үнэт зүйлд нөлөөлөх замаар явагдах болсон. Үүнийг танин мэдэхүйн дайн хэмээн тодорхойлж, НАТО болон барууны судлаачид хүний сэтгэхүйг “шинэ тулааны талбар” гэж үзэх болсон байна.

Монгол Улс шиг хүн ам цөөн, мэдээллийн орчин өндөр нээлттэй, олон нийтийн сүлжээний хэрэглээ өндөртэй улсад танин мэдэхүйн дайны нөлөөлөл нь улс төрийн тогтвортой байдал, нийгмийн эв нэгдэл, итгэлцэлд шууд эрсдэл учруулах боломжтой. Иймээс энэхүү өгүүлэл нь олон нийтийн сүлжээг танин мэдэхүйн дайны хэрэгсэл болгож буй гол асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр задлан шинжилж, бодлогын түвшинд авч үзэхийг зорив.

Орчин үеийн аюулгүй байдлын орчинд дайны мөн чанар мэдэгдэхүйц өөрчлөгдөж байгаа ба цэргийн ажиллагаа нь кибер орчин, мэдээллийн орчин, танин мэдэхүйн орчин зэрэг шинэ ажиллагааны салбаруудад өргөжин тэлж байна. Эдгээрээс танин мэдэхүйн орчин нь хувь хүн болон нийгэм мэдээллийг хэрхэн хүлээн авч, бодит байдлыг хэрхэн тайлбарлаж, шийдвэр гаргадаг үйл явцад нөлөөлөх стратегийн чухал талбар болж байна. Танин мэдэхүйн дайн нь мэдээллийг зориудаар ашиглах, сэтгэлзүйн эмзэг байдлыг ашиглах замаар хүний ойлголт, итгэл үнэмшил, зан төлөвт нөлөөлөхийг зорьдог. Ийм нөхцөлд мэдээллийн технологи болон дижитал харилцааны платформууд нөлөөллийн ажиллагаа явуулах гол хэрэгсэл болж байна.

Олон нийтийн сүлжээний платформуудын хурдацтай хөгжил нь дэлхийн мэдээллийн экосистемийг үндсээр нь өөрчилсөн. Facebook, X (хуучнаар Twitter), YouTube болон бусад дижитал сүлжээнүүд мэдээллийг хил хязгааргүйгээр богино хугацаанд олон сая хэрэглэгчдэд хүргэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд эдгээр платформууд нь харилцаа холбоо, мэдээлэл солилцох, нийгмийн харилцааг өргөжүүлэх боломжийг олгодог боловч нөгөө талаас мэдээллийн орчинд шинэ эмзэг байдлыг бий болгож төрийн болон төрийн бус оролцогчид олон нийтийн сүлжээг ашиглан төөрөгдүүлсэн мэдээлэл тараах, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, зохион байгуулалттай мэдээллийн нөлөөллийн ажиллагаа явуулах боломжийг олгож байна.

Олон нийтийн сүлжээний нэг онцлог нь алгоритмд суурилсан санал болгох системээр дамжуулан сэтгэл хөдлөл өдөөсөн, анхаарал татахуйц агуулгыг өргөн хүрээнд түгээх чадвар юм. Энэ механизм нь санамсаргүй байдлаар худал мэдээлэл, зориудаар тараасан буруу мэдээлэл, манипуляци бүхий өгүүлэмжүүдийг хурдан тархах нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн автоматжуулсан бот сүлжээ, хуурамч хаяг,

зохион байгуулалттай онлайн кампанит ажлуудыг ашиглан тодорхой мэдээллийг зориудаар түгээж, олон нийтийн өргөн дэмжлэгтэй мэт харагдуулах боломж бий болдог. Иймээс олон нийтийн сүлжээ нь танин мэдэхүйн дайныг өргөн хүрээнд явуулах хэрэгсэл болж байна.

Мөн тус хэрэгслээр дамжуулаг мэдээллийн орчныг зориудаар манипуляци хийх нь төрийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг сулруулах, улс төрийн туйлшралыг нэмэгдүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Ялангуяа институцийн чадавх харьцангуй хязгаарлагдмал жижиг улс орнууд гадаад мэдээллийн нөлөөллийн ажиллагаанд илүү эмзэг байх магадлалтай.

Ийм нөхцөл байдлын хүрээнд энэхүү судалгааны ажил нь олон нийтийн сүлжээг танин мэдэхүйн дайны хэрэгсэл болгон ашиглаж буй асуудлыг авч үзсэн ба тодруулбал, дижитал платформууд хэрхэн манипуляци бүхий өгүүлэмжийг түгээх, зохион байгуулалттай нөлөөллийн кампанит ажиллагааг дэмжих, олон нийтийн ойлголт болон шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжийг бүрдүүлж байгааг шинжилнэ. Ингэснээр орчин үеийн мэдээллийн мөргөлдөөний шинж чанар, түүний үндэсний аюулгүй байдал болон нийгмийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг илүү гүнзгий ойлгоход хувь нэмэр оруулахыг зорилоо.

II. Судалгааны арга зүй

2.1. Танин мэдэхүйн дайны үндэс

Танин мэдэхүйн дайн бол хүний оюун ухаанд хүмүүсийн сэтгэх, итгэх, бодит байдлыг хэрхэн хүлээн авахыг өөрчлөхийг эрмэлздэг уламжлалт бус дайны хэлбэр юм. Танин мэдэхүйн дайн нь хүний танин мэдэхүйн үйл явцыг удирдах, итгэлийг сулруулах, нийгмийг төөрөгдүүлэх, зан үйлийг өөрчлөхийн тулд технологи (хиймэл оюун ухаан, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл)-ийг ашигладаг. Энэ нь зөвхөн мэдээлэл төдий зүйл биш бөгөөд мэдээллийн агуулгыг тархины үйл ажиллагааг удирдах хэрэгсэл болгож буйд оршдог. Энэхүү ойлголтоор дайсныг зэвсэгт мөргөлдөөнд ялахын оронд түүний юуг үнэн гэж ойлгох, юунд итгэх, ямар шийдвэр гаргах, хэрхэн хариу үйлдэл үзүүлэх сэтгэхүйн суурийг алгуур, системтэйгээр өөрчлөхөд чиглэдэг. Танин мэдэхүйн дайн нь зөвхөн худал мэдээлэл түгээхээр хязгаарлагдахгүй бөгөөд соёл, үнэт зүйл, түүхэн ой санамж, үндэсний ижилсэл, төр засагт итгэх итгэл зэрэг гүн давхаргуудыг онилон нөлөөлдөг онцлогтой. Үүний хүрээнд сошиал медиагийн алгоритм, хиймэл оюунд суурилсан өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга, deepfake болон автоматжуулсан мэдээллийн сүлжээг ашиглан айдас, уур хилэн, үл итгэх байдал, нийгмийн туйлшралыг өдөөж, улмаар тухайн нийгэм өөрөө бодлогын болон аюулгүй байдлын хувьд өөрийгөө сулруулах шийдвэрүүдийг гаргахад хүргэдэг. Судлаачид танин мэдэхүйн дайныг орчин үеийн дайны “тав дахь орон зай” хэмээн тодорхойлж, уг орон зайд ялалт байгуулах нь цэргийн хүчнээс гадна боловсрол, стратегийн харилцаа, ард түмэн – төр засгийн итгэлцэл, нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавхаас шууд хамаарна гэж үздэг. Иймд танин мэдэхүйн дайн нь зөвхөн цэргийн бус, харин үндэсний аюулгүй байдал, ардчилсан тогтолцоо, нийгмийн тогтвортой байдлыг бүхэлд нь хамарсан урт хугацааны стратегийн сорилт болж байгаа юм (*Giannopoulos 2020*).

2.2. Мэдээллийн дайн ба танин мэдэхүйн дайны ялгаа

Мэдээллийн дайн (information warfare) болон танин мэдэхүйн дайн (cognitive

warfare) нь хоорондоо уялдаа холбоотой боловч зорилго, нөлөөлөх орон зай, стратегийн цар хүрээгээрээ ялгаатай ойлголтууд юм. Мэдээллийн дайн нь голчлон мэдээллийн урсгалыг хянах, гуйвуулах, худал эсвэл ташаа мэдээг зориудаар түгээх замаар дайсны ойлголтод шууд, богино хугацааны нөлөө үзүүлэхэд чиглэдэг. Энэ нь ихэвчлэн тодорхой зорилтот үйл явдал, сонгууль, хямралын үед олон нийтийн санаа бодлыг өөрчлөх, будилаан үүсгэх тактик шинжтэй ажиллагаагаар илэрдэг. Харин танин мэдэхүйн дайн нь мэдээллийг зүгээр нэг гуйвуулах үйлдлээр зогсохгүй, тухайн нийгэм, бүлэг, хувь хүний сэтгэх хэв маяг, үнэт зүйл, итгэл үнэмшил, шийдвэр гаргах логикийг урт хугацаанд өөрчлөх стратегийн зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, мэдээллийн дайн нь “юу бодох”-д нөлөөлөхийг зорьдог бол танин мэдэхүйн дайн нь “яаж бодох”-ыг өөрчлөхөд чиглэдэг (*NATO 2020*).

2.3. Олон нийтийн сүлжээ яагаад танин мэдэхүйн дайны хэрэгсэл болж байна вэ

Олон нийтийн сүлжээ нь орчин үеийн нийгэмд мэдээлэл түгээх үндсэн орчин болохын зэрэгцээ танин мэдэхүйн дайны хамгийн үр ашигтай хэрэгсэл болж хувираад байна. Үүний гол шалтгаан нь сошиал платформууд хүний анхаарал, сэтгэл хөдлөл, итгэл үнэмшил, зан үйлийн хариу үйлдэл дээр суурилсан алгоритмаар ажилладагт оршдог. Өөрөөр хэлбэл, олон нийтийн сүлжээ нь мэдээллийг зүгээр дамжуулдаг суваг бус, харин хэрэглэгч хэрхэн бодож, юунд итгэж, ямар шийдвэр гаргахыг тодорхой хэмжээнд чиглүүлдэг танин мэдэхүйн орчин юм. Ийм алгоритмд тулгуурласан экосистем нь айдас, уур хилэн, туйлшрал зэрэг хүчтэй сэтгэл хөдлөлийг өдөөдөг контентыг илүү хурдтай түгээж, бодит байдлыг гуйвуулсан ойлголтыг хэвийн мэт болгож төлөвшүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Нөгөөтээгүүр, олон нийтийн сүлжээ нь echo chamber буюу ижил үзэл бодол давтагдан баталгааждаг орчныг бий болгож, хувь хүний шүүмжлэлт сэтгэлгээг сулруулдаг. Ингэснээр хэрэглэгч өөрийн итгэл үнэмшилтэй нийцсэн мэдээллийг “үнэн” хэмээн хүлээн зөвшөөрч, зөрүүтэй байр суурийг дайсагнасан, эсвэл худал мэтээр ойлгох хандлага нэмэгддэг. Танин мэдэхүйн дайнд энэ онцлогийг ашиглан тодорхой улс, нийгмийн бүлгүүдийг зориудаар хуваах, үл итгэх байдал бий болгох, ард иргэдийн төрд итгэх итгэлийг алдагдуулах стратеги хэрэгжүүлдэг. Судлаачдын үзэж буйгаар сошиал медиа нь ийм байдлаар зөвхөн мэдээллийн дайн явуулах бус, харин хүний сэтгэх хэв маягийг удаан хугацаанд өөрчлөх замаар танин мэдэхүйн дайны үндсэн хэрэгсэл болж байна.

Цаашлаад хиймэл оюунд суурилсан bot, автоматаар үүссэн аккаунт, deepfake технологи нэвтэрснээр олон нийтийн сүлжээнд бодит болон зохиомол мэдээллийн зааг улам бүдгэрч, үнэн мэдээлэлд итгэх итгэл сулрах нөхцөл бүрдэж байна. Энэ нь эцсийн дүндээ нийгэм өөрөө бодлогын болон аюулгүй байдлын хувьд өөрийгөө сулруулах шийдвэр гаргах орчныг бүрдүүлдэг. Иймээс олон улсын судалгаанд олон нийтийн сүлжээг танин мэдэхүйн дайны “үндсэн дэд бүтэц” хэмээн тодорхойлж, үүнийг сөрөн тэсвэрлэх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавхын салшгүй хэсэг гэж үзэж байна (*Sunstein 2017*).

2.4. Зохион байгуулалттай танин мэдэхүйн нөлөөллийн ажиллагаа

Зохион байгуулалттай танин мэдэхүйн нөлөөллийн ажиллагаа нь тодорхой улс, байгууллага эсвэл ашиг сонирхлын бүлэг урьдчилан боловсруулсан стратеги,

төлөвлөгөө, зохион байгуулалтын хүрээнд хувь хүн, нийгэм, засаглалын сэтгэхүй, итгэл үнэмшил, зан үйлийн шийдвэр гаргалтад системтэйгээр нөлөөлөх зорилготойгоор хэрэгжүүлдэг үйл ажиллагаа юм. Ийм ажиллагаа нь нэг удаагийн худал мэдээлэл түгээхээс ялгаатайгаар урт хугацаанд давтамжтай явагддагаараа онцлогтой. Зохион байгуулалттай нөлөөллийн ажиллагаанд социал медиагийн алгоритм, автоматжуулсан bot болон хуурамч аккаунтын сүлжээ, зорилтот бүлэгт чиглэсэн мессеж (micro-targeting), хиймэл оюунд суурилсан контент үйлдвэрлэл, deepfake технологи зэргийг хослуулан ашигласнаар үнэн болон худал мэдээллийн заагийг бүдгэрүүлж, айдас, үл итгэх байдал, нийгмийн туйлшралыг аажмаар хэвийн мэт ойлгуулахад чиглэдэг. Судлаачдын тэмдэглэснээр ийм ажиллагааны эцсийн зорилго нь зорилтот нийгмийг шууд албадлагагүйгээр өөрөө өөртөө ашиггүй, стратегийн хувьд сулруулах шийдвэр гаргахад хүргэдэг хэмээн үздэг юм.

2.5. Хиймэл оюун ба итгэлцлийн хямрал

Хиймэл оюун (AI) болон түүнд суурилсан гүн хууралтын (deepfake) технологи нь мэдээлэл үйлдвэрлэх, түгээх хурд, цар хүрээг эрс нэмэгдүүлснээр орчин үеийн нийгэмд итгэлцлийн хямралыг бий болгож буй гол хүчин зүйлсийн нэг болж байна. Гүн хууралт (deepfake) нь бодит мэт харагдах дүрс, дуу, бичвэрийг зохиомлоор үүсгэх боломж олгодог тул иргэдийн “юу үнэн, юу худал вэ?” гэсэн ялган таних чадварыг сулруулж, улмаар мэдээлэлд итгэх итгэлийг системтэйгээр алдагдуулдаг. Судлаачдын үзэж буйгаар энэхүү технологи нь зөвхөн худал мэдээлэл түгээх хэрэгсэл бус, харин хүний танин мэдэхүйн үндсэн механизм болох итгэлцэл, баталгаажуулалт, баримтад тулгуурлах логикийг эвдэж, нийгмийн шийдвэр гаргалтад гүнзгий нөлөөлөх стратегийн шинжтэй хүчин зүйл юм.

Танин мэдэхүйн дайны хүрээнд гүн хууралт (deepfake) болон хиймэл оюунаар контентыг ашигласнаар бодит үйл явдал, албан ёсны мэдэгдэл, олны танилын байр суурийг гуйвуулж, итгэх итгэлийг алдагдуулах боломж бүрддэг. Үүний улмаас иргэд “ямар ч мэдээлэлд бүрэн итгэх боломжгүй” гэх хандлагад шилжиж, үнэн мэдээлэл ч худал мэтээр хүлээн зөвшөөрөгдөх ерөнхий үл итгэх орчин бий болдог. Энэ үзэгдлийг судалгаанд “liar’s dividend” буюу худал мэдээлэл олширсноор бодит үнэнийг үгүйсгэх боломж нэмэгддэг сөрөг нөлөө хэмээн тодорхойлдог. Ийм нөхцөлд нийгэм зөвхөн худал мэдээллээс хохирох бус, харин үнэнд итгэх чадавхаа алдах нь хамгийн том аюул болдог.

Олон улсын аюулгүй байдлын судалгаанд хиймэл оюун ба гүн хууралтын (deepfake) технологи нь танин мэдэхүйн дайныг дараагийн шатанд гаргаж, итгэлцлийн хямралыг стратегийн зэвсэг болгон ашиглах боломжийг олгож байна гэж дүгнэдэг. Энэ нь ардчилсан тогтолцоо, сонгуулийн процесс, үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх шийдвэр гаргалтад урт хугацааны сөрөг үр дагавар учруулах эрсдэлтэй (*Citron 2018*). Иймд итгэлцлийн хямралыг даван туулах нь зөвхөн технологийн асуудал бус, харин мэдээллийн дархлаа, шүүмжлэлт сэтгэлгээ, засаглалын ил тод байдал, стратегийн харилцан хамаарлыг хамарсан цогц бодлогын сорилт болж байна (*Cristian Vaccari 2020*).

III. Хэлэлцүүлэг

Сүүлийн жилүүдэд танин мэдэхүйн дайн, зохион байгуулалттай мэдээллийн манипуляцийн эсрэг хариу арга хэмжээг судлах чиглэлд “хамгаалалт” (defence)

гэх ойлголт нь уламжлалт утгаа тэлж, нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавх (societal resilience)-тай салшгүй холбогдон хөгжиж байна. Судлаачид болон бодлого боловсруулагчид танин мэдэхүйн дайныг дан ганц гаднын заналхийлэл бус, харин нийгмийн дотоод эмзэг байдлыг ашиглан өрнөдөг системийн сорилт гэж үзэх болсон нь хамгаалалтын судалгааны шинэ парадигмыг бий болгожээ.

НАТО-ийн Chief Scientist Report-д танин мэдэхүйн дайныг “нийгмийн оюун санааны дархлааг сулруулах замаар стратегийн давуу байдал олж авах оролдлого” хэмээн тодорхойлж, үүний эсрэг хамгийн тогтвортой хариу нь итгэлцэл, боловсрол, засаглалын найдвартай байдалд суурилсан сөрөн тэсвэрлэх чадавх хэмээн дүгнэсэн байдаг (*Organization 2021*).

Академик судалгаанд сөрөн тэсвэрлэх чадавхад суурилсан хандлага нь танин мэдэхүйн дайныг “хориглох боломжтой асуудал” бус, харин удирдаж, тэсвэрлэж, дасан зохицох шаардлагатай эрсдэл гэж үздэг бөгөөд энэ хүрээнд худал мэдээлэл, манипуляцийн эсрэг “үнэн”-ийг дангаар нь тулгах оролдлого хангалтгүй бөгөөд харин иргэд мэдээлэлд шүүн тунгаах чадвартай, төр засагт итгэх үндэслэлтэй, хямралын үед албан ёсны мэдээлэлд хандах дадалтай байх нь хамгаалалтын бодлогын гол зорилго болж байна (*Norris 2008*).

Европын холбоонд ч мөн адил чиг хандлага ажиглагддаг ба Европын Комиссоос баталсан “Code of Practice on Disinformation” болон түүнтэй уялдсан бодлогын баримт бичгүүдэд контент устгах, аккаунт хаах зэрэг шууд арга хэмжээнээс гадна ил тод байдал, алгоритмын хяналт, иргэдийн мэдээллийн боловсрол зэрэг урт хугацааны сөрөн тэсвэрлэх чадавхыг дэмжих зорилтуудыг онцолсон. Энэ нь танин мэдэхүйн дайныг зөвхөн платформын түвшинд бус, нийгмийн экосистемийн түвшинд ойлгож эхэлснийг харуулж буй явдал юм.

Зарим судлаачид танин мэдэхүйн дайны эсрэг хамгаалалтыг “иргэний хамгаалалт” (civic defence)-ын ойлголттой холбон авч үзэх болсон. Энэ хүрээнд иргэн бүр мэдээллийн орчинд идэвхгүй хэрэглэгч бус, харин эрсдэлийг таних чадвартай оролцогч байх ёстой гэж үздэг. Медиа болон мэдээллийн боловсрол (media and information literacy) нь ийнхүү танин мэдэхүйн дайны эсрэг “зөөлөн хамгаалалтын” гол хэрэгсэл болон төлөвшиж байна.

Гэсэн хэдий ч одоо хүртэл дээрх арга замуудад хязгаарлалт ажиглагдаж байгаа бөгөөд нэгдүгээрт, дээрх хандлага нь ихэвчлэн барууны ардчилсан, итгэлцэл харьцангуй өндөр орнуудын жишээнд тулгуурласан байдаг. Хоёрдугаарт, жижиг улс, хүн ам цөөн, мэдээллийн зах зээл хязгаарлагдмал нөхцөлд тус арга барил хэрхэн өөрөөр илэрч болох талаар системтэй судалгаа харьцангуй цөөн байдаг. Гуравдугаарт, олон нийтийн сүлжээний алгоритм, AI-д суурилсан контентын нөлөө, иргэн-төр хоорондын итгэлцлийн динамик харилцааг нэг загварт нэгтгэсэн судалгаа хомс хэвээр байна.

Иймээс энэхүү өгүүлэл нь танин мэдэхүйн дайны эсрэг хамгаалалтыг цэргийн болон хууль эрх зүйн арга хэмжээгээр хязгаарлах бус, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх-ын хүрээнд ойлгож, олон нийтийн сүлжээ, иргэдийн төр засагтаа итгэх итгэл, иргэний танин мэдэхүйн чадварын огтлолцлыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлахыг зорилоо.

Дүгнэлт

Энэхүү судалгаа нь олон нийтийн сүлжээ орчин үеийн танин мэдэхүйн дайны гол хэрэгсэл болон хувирч буйг онолын болон бодлогын түвшинд нотлон харуулахыг зорив. Судалгааны үр дүнгээс үзэхэд танин мэдэхүйн дайн нь уламжлалт мэдээллийн дайн, сэтгэл зүйн ажиллагааны үргэлжлэл бус, харин хүний ухамсар, ойлголт, итгэл үнэмшил, нийгмийн хамтын байдал, эв нэгдлийг онилсон системийн шинжтэй стратегийн шинжтэй шинэ хэлбэрийн дайн болох нь харагдаж байна. Олон нийтийн сүлжээний алгоритмд суурилсан зорилтот чиглүүлэлттэй, зохион байгуулалттай нөлөөллийн ажиллагаа, хиймэл оюунд суурилсан контентын тархалт зэрэг хүчин зүйлс нь энэхүү дайныг хурдасгаж, цар хүрээг нь өргөжүүлж байна.

Судалгаанд хийсэн тойм, шинжилгээнээс харахад танин мэдэхүйн дайны гол зорилго нь тодорхой үзэл санаанд итгүүлэхээс илүүтэйгээр **итгэлцлийг доройтуулах, эргэлзээг хэвшүүлэх, нийгмийг туйлшруулах** явдал юм. Энэ нь олон нийтийн сүлжээгээр дамжин богино хугацаанд өргөн хүрээнд хэрэгжих боломжтой бөгөөд засаглалын нэр хүнд, ардчилсан үйл явц, нийгмийн эв нэгдэлд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг. Иймээс танин мэдэхүйн дайны аюул занал нь зөвхөн аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хамаарах асуудал бус, харин нийгмийн тогтолцооны суурь асуудал гэдгийг судалгаа харуулж байна.

Монгол Улсын нөхцөлд олон нийтийн сүлжээний хэрэглээ өндөр, мэдээллийн зах зээл харьцангуй хязгаарлагдмал, төр засагт итгэх итгэл эмзэг байх нь танин мэдэхүйн дайны нөлөөлөлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүйг судалгаа онцолж байна. Иймээс шинэ төрлийн аюул болох танин мэдэхүйн дайныг үндэсний аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын бодлоготой уялдуулан авч үзэх зайлшгүй шаардлага бий боллоо. Олон нийтийн сүлжээ, иргэн, төр хоорондын харилцан хамаарлыг бодлогын түвшинд ойлгож, зохицуулахгүйгээр танин мэдэхүйн орчин дахь эрсдэлийг үр дүнтэй бууруулах боломж хязгаарлагдмал хэвээр байх болно.

Эцэст нь дүгнэхэд, олон нийтийн сүлжээ нь орчин үеийн танин мэдэхүйн дайныг өдөөж буй томоохон хүчин зүйл болж, мэдээллийн орчныг аюулгүй байдлын стратегийн чухал талбар болгож байна. Үүнээс улбаалан судалгааны шинэ чиглэл, бодлогын шинэ хандлага шаардагдаж байгаа ба цаашдын судалгаанд танин мэдэхүйн дайны нийгэм-сэтгэлзүйн үр дагаврыг эмпирик аргаар хэмжих, жижиг улсын нөхцөлд сөрөн тэсвэрлэх чадавхыг үнэлэх арга зүй боловсруулах, мөн хиймэл оюунд суурилсан контентын нөлөөллийг бодлогын түвшинд зохицуулах механизмд анхаарах шаардлагатай болж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Citron, Bobby Chesney and Danielle. 2018. “Deep Fakes: A Looming Challenge for Privacy, Democracy, and National Security.” *107 California Law Review* 1753 (2019) 68.
2. Cristian Vaccari, Andrew Chadwick. 2020. “Deepfakes and Disinformation: Exploring the Impact of Synthetic Political Video.” *Deception, Uncertainty, and Trust in News. Social Media + Society*, 6(1).
3. Giannopoulos, Georgios, Hannah Smith, and Mariarosaria Theodoridou. 2020. *Cognitive Warfare: Conceptual Framework and Approaches*. Brussels: European

Union Institute for Security Studies.

4. NATO. 2020. *NATO's Approach to Cognitive Warfare*. Brussels: NATO Innovation Hub.
5. Norris, Fran. 2008. “Community Resilience as a Metaphor, Theory, Set of Capacities, and Strategy for Disaster Readiness.” *American Journal of Community Psychology* 1-2.
6. Organization, NATO Science and Technology. 2021. *Cognitive Warfare*. Research Report, Brussels: The Chief Scientist Research Reports .
7. Sunstein, Cass R. 2017. *Republic: Divided Democracy in the Age of Social Media*. New York : Princeton University Press.